



“АСБИ” ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 04 сарын 11

Дугаар 01

Улаанбаатар хот

Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон Санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Монгол улсын Компаний тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтыг удирдлага болгон АСБИ ХК-ийн 2018 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2019 оны 4 дугаар сарын 11-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “АСБИ” ХК-ийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар “Хангалттай” гэж дүгнэсэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг зөвшөөрч баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



Д.ЛХАГВАСҮРЭН



“АСБИ” ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 04 сарын 11

Дугаар 02

Улаанбаатар хот

Компанийн 2018 оны Хараат бус аудиторын тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

“АСБИ” ХК-ийн 2018 оны Хараат бус аудиторын тайлантай танилцаж, Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2019 оны 4 дугаар сарын 11-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “АСБИ” ХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудиторын тайланг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг зөвшөөрч баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



Д.ЛХАГВАСҮРЭН



“АСБИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 04 сарын 11

Дугаар 03

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Компаний тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь хэсэг, 77 дугаар зүйлийн 77.2, 77.3 дахь хэсэг, 2019 оны 4 дүгээр сар 11-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. Компаний ТУЗ-ийн гишүүнийг 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж дор дурьдсан хүмүүсийг ажиллуулахаар баталсугай. Үүнд:

ТУЗ-ын ердийн гишүүнд


- 1.1 Л.Сүмбанд
- 1.2 Д.Лхагвасүрэн
- 1.3 Б.Должиндэмбэрэл
- 1.4 Б.Доржсүрэн
- 1.5 Ч.Дашцэрэн
- 1.6 Л.Түвшинзаяа

ТУЗ-ын хараат бус гишүүнд

- 1.7 Э.Буянтогтох
- 1.8 Ц.Одончимэг
- 1.9 Л.Нямдаваа

2. Компаний үр ашгийг дээшлүүлж, үйл ажиллагааг идэвхижүүлэх, менежментийг сайжруулах. Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг хянаж туслах чиглэлээр идэвх гарган ажиллахыг ТУЗ-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



Д.ЛХАГВАСҮРЭН



“АСБИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 04 сарын 11

Дугаар 04

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны төсвийг батлах тухай

Компаний тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, 62.1.15 дахь заалт, 2019 оны 4 дүгээр сар 11-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. “АСБИ”ХК (цаашид “компани”)-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл болон Гүйцэтгэх Удирдлагын 2019 оны төсвийг 7,000,000 төгрөгөөр тогтоосугай.
2. Төсвийн зардалд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргад даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



Д.Лхагвасүрэн

Д.ЛХАГВАСҮРЭН